

“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ” ГЭРЭЛ ЗУРГИЙН ЗОРИЛТОТ ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАЙЛАН

2023.01.25

Дархан-Уул аймаг

Соёлын Яам болон Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар, Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо, аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо, МГЗНХ-ны Дархан-Уул аймаг дахь салбартай хамтран гэрэл зургийн холбооны гишүүн болон чөлөөт гэрэл зурагчдын 40 бүтээлээс бүрдсэн **“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ”** гэрэл зургийн зорилтот үзэсгэлэнг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 25-ны өдөр хүртэл зохион байгууллаа.

Нээлтийг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр аймгийн Эмэгтэйчүүдийн ордонд зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд МГЗНХ-ны ерөнхийлөгч Ц.Батбаатар нээн үг хэллээ. Нээлтийн үеэр соёлын байгууллагуудын удирдлагууд ажилтан, албан хаагчид, мөн “Монголын газарзүйн багш нарын анхдугаар чуулга уулзалт”-д оролцогч 10 аймаг, 4 дүүргийн 202 багшийн төлөөлөл, гэрэл зурагчид, анхан шатны Эмэгтэйчүүдийн зөвлөл, гишүүн байгууллагууд, хүүхдийн дугуйлангийн сурагчид зэрэг хүрэлцэн ирж оролцлоо.



Тус үзэсгэлэнг 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 01 дүгээр сарын 18-ны өдрүүдэд Эмэгтэйчүүдийн холбооны байранд 10 хоног үзэсгэлэнг толилуулж, аймгийн Тамгын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс 20-ны өдрүүдэд толилууллаа. Мөн Хонгор сумын Засаг даргын Тамгын газарт 2 хоног, Хонгор сумын Соёлын төвд 3 хоног нийт 17 өдрийн турш олны хүртээл боллоо.



Зорилтот үзэсгэлэнг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хамт олноороо, иргэд, эцэг эх, хүүхэд багачууд зэрэг нийт 500 гаруй үзэгч үзэж сонирхсон бөгөөд ирсэн үзэгчид “Эх дэлхийгээ хайрлан хамгаалахын ач холбогдлыг хүн бүрт ойлгуулж мэдрүүлсэн үзэсгэлэн” хэмээн сэтгэгдэл өндөр байлаа. Мөн үзэсгэлэнд дэлгэгдсэн бүтээлээс зочид худалдан авалт хийж гэрэл зурагчдаа дэмжлээ.

 СОЁЛЫН ЯАМ
  ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

ТАЛАРХАЛ

“МОНГОЛЫН ГЭРЭЛ ЗУРАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО”-ны хамт олонд

Соёлын яамны дэмжлэлтэйгэр бүх нийтийн соёлын боловсрол олгох, соён газаруулаж “УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛ” зорилтот гэрэл зургийн үзэсгэлэнг Дархан-Уул аймагт амжилттай зохион байгуулахад хамтран ажилласан их үйлсэд талархал илэрхийлье

Та бидний соён газаруулах ажилд амжилас өндөр амжилтын хүсэн өглөө

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР
2023.01.25



Мөн хамтран ажилласан Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоонд аймгийн Соёл, урлагийн газраас “ТАЛАРХАЛ” гардуулж өглөө.

ТАНИЛЦСАН:

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

С.ТУЯА

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ЧИНБИЛЭГ